



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/604

Хэрлэн сум

Мал, тэжээвэр амьтдын
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1"в", 20 дугаар зүйлийн 20.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг 2022 оны 12 дугаар сарын 07-оос 2022 оны 12 дугаар сарын 17-ны хооронд явуулсугай.

2.2022 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Орлогч дарга:	Г.Сэдэдмаа	Аймгийн Статистикийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Ц.Батхишиг	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	С Нямдаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	А.Гантөмөр	Татварын хэлтсийн дарга
	Ж.Энх-Амгалан	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
	Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга

2.

Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
Б.Хэрлэнчимэг	Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
Н.Нямхатан	Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Э.Хонгорзул	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
Ч.Пүрэвдорж	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга
С.Мөнхцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Х.Уртнасан	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

3.Жилийн эцсийн мал тооллогод зар цуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

4.Мал тооллогод зарцуулах 13,384,000 (арван гурван сая гурван зуун наян дөрвөн мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлт шийдвэрлэх зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д зөвшөөрсүгэй.

5.Жилийн эцсийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, сумдын ажлын хэсэгт мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд Ажлын хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
11 дугаар сарын 29-ны
Ажвоц дугаар захирамжийн хавсралт

2022 ОНЫ МАЛ ТООЛЛОГОНД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Сумдын нэр	Олгох зардал (мян.төг)	Хяналтаар ажиллах комиссын зардал (мян.төг)	Бүгд
1	Галшар	504 0		
2	Баянхутаг	616 0		
3	Баянмөнх	358 4		
4	Дархан	504 0		
5	Дэлгэрхаан	481 6		
6	Жаргалтхаан	392 0		
7	Цэнхэрмандал	526 4		
8	Өмнөдэлгэр	784 0		
9	Батширээт	481 6		
10	Биндэр	537 6		
11	Баян-Адрага	425 6		
12	Дадал	414 4		
13	Норовлин	481 6		
14	Батноров	560 0		
15	Баян-овоо	448 0		
16	Мөрөн	470 4		
17	Хэрлэн	515 2		
18	Бор-Өндөр	280.0		
19	Бэрх	280.0		
20	Хэрлэнбаянулаан	280.0		
21	Гурванбаян	280.0		
22	Номгон	280.0		
23	Ишгэнтөлгой	280.0		
24	Комиссын гишүүдийн хяналтын зардал		3203.2	
	Дүн	10180.8	3203.2	13.384.0